



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Сургалтын нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай


Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг хавсралтаар тогтоон мөрдсүгэй.
2. Магистрантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.4 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
3. Докторантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.9 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
4. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.2 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
5. ШУТИС-д хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэл дээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.
6. ШУТИС-д суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тооцохдоо энэхүү тогтоолын 1-5 дахь заалтуудыг баримталсугай.
7. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Шинжлэх ухаан технологийн ахлах сургууль, ШУТИС-Коосен технологийн коллежийн 2019-2020 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 3.000.000 (гурван сая) төгрөгөөр, Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 1.200.000 (нэг сая хоёр зуун мянган) төгрөгөөр тогтоосугай.


8. Сургалтын төлбөрийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан 2019 оны батлагдсан төсөвт шаардлагатай тодотголыг хийж Удирдах зөвлөлд оруулж хэлэлцүүлэхийг захирал Б.Очирбат, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (Б.Сүхбат), Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ) нарт даалгасугай.

9. Шинэчлэн тогтоосон шинэ элсэгчийн нэг кредитийн үнэлгээнээс нэмэгдэх эх үүсвэрийг сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад зарцуулж 2019 оны 12 дугаар сард багтаан Удирдах зөвлөлд тайлагнахыг захирал Б.Очирбат, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (Б.Сүхбат), Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ) нарт даалгасугай.

ДАРГА



Д.БАДАРЧ



2019-2020 оны хичээлийн жилд мөрдөх нэг кредитийн үнэлгээ

Д/Д	Сургууль	Хөтөлбөрийн ангилал	Нэг кредитийн үнэлгээ /төгрөгөөр/		
			2019-2020 оны хич. жилд элсэгч	2018-2019 оны хич.жилд элссэн	2018 оноос өмнө элссэн
1	БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	Инженер, технологи	90,800	82,390	80,300
2	ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ			82,390	80,300
3	МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ			82,390	80,300
4	МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ			86,790	84,590
5	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ			82,390	80,300
6	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ			84,370	82,170
7	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	Нийгмийн ухаан	88,800	86,790	84,590
8	ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ	Хэрэглээний шинжлэх ухаан	79,300	72,160	70,400
9	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ			74,360	72,490
10	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ			75,790	73,920
ШУТИС дундаж				82,042	